

АНУ-БНХАУ-ЫН УЛС ТӨРИЙН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ХЭТИЙН ТӨЛӨВ

Х. Шинэчимэг¹

Товч агуулга:

Дэлхийн хоёр их гүрэн болох АНУ-БНХАУ (Америк-Хятад)-ын харилцаа нь өнөөгийн олон улсын харилцааны нэн сонирхолтой асуудлуудын нэг яах аргагүй мөн. Дипломат харилцаа тогтоогоод 38 дахь жилийнхээ нүүрийг үзэж байгаа хоёр орны харилцаа дэлхийн улс төр, эдийн засгийн төлөв байдалд нөлөөлөхүйц хэв шинжийг нэгэнт буй болгож чаджээ.

Энэхүү өгүүлэлд Америк-Хятадын улс төрийн харилцааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага (цаашид хэрхэн өрнөх болон “Нэг Хятад” бодлого, “Ази, Номхон далайн дахин тэнцвэржүүлэх бодлого”-д АНУ-ын шинэ ерөнхийлөгч Д.Трампын засаг захиргаа хэрхэн хандах) хэрхэн өрнөх талаар таамаг дэвшүүлэхийг зорив.

Судлаачдын анхаарлын төвд буй хоёр өөр тогтолцоо бүхий орнууд болох Америк-Хятадын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, чиг хандлага нь хэд хэдэн хүчин зүйлээс шууд хамаарч байна. Дэлхийн эдийн засаг, бүс нутгийн аюулгүй байдлыг тодорхойлохуйц хоёр орон дипломат харилцаа тогтоохоос өмнө хүйтэн хөндий уур амьсгалтай байсан гэж хэлж болно. 1972 оны 2 дугаар сард БНХАУ-ын Ерөнхий сайд Жоу Энълайгийн урилгаар АНУ-ын Ерөнхийлөгч Ричард Никсон анх Удаа БНХАУ-д айлчилснаар

¹ *ШУА-ийн ОУХХ-гийн эрдэм шинжилгээний ажилтан, Kh.shinechimeg@yahoo.com*

хоёр орны орчин үеийн харилцааны суурь тавигдаж, 1979 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр албан ёсоор дипломат харилцаа тогтоосон байдаг.

Өнгөрсөн хугацаанд хоёр улс хамтарсан мэдэгдэл гурав (1972.2.28, 1978.12.16, 1982.8.17), хамтарсан тунхаглал гурав (1997.10.29, 2009.11.17, 2011.1.19), хамтын ажиллагааны 100 гаруй яриа хэлэлцээний механизмыг бий болгожээ. Үүнээс 2009, 2011 оны тунхаглалыг Б.Обама, Ху Жинтао нарын Засгийн газрын үед гаргажээ.

Америк-Хятадын улс төрийн харилцааны өнөөгийн байдал

Ж.Бушийн дараа Ардчилсан намаас ялалт байгуулан гарч ирсэн Б.Обамагийн Засгийн газар бүс нутгийн, тэр дундаа Ази, Номхон далайн орнууд руу чиглэсэн бодлогоо “Ази, Номхон далайн дахин тэнцвэржүүлэх бодлого”^{*} хэмээн тодорхойлсон байна. Мөн “Америк-Хятадын харилцаа нь дэлхийн ирээдүйн хөгжилд чухал ач холбогдолтой бөгөөд *Бид өрсөлдөгч биш харин стратегийн хамтрагчид юм*”² хэмээн тодорхойлсон явдал хоёр орны харилцаа эерэг хандлагатай байхаар төлөвлөгдсөн болохыг харуулж байна.

2009 онд хоёр тал тус тусын үндсэн эрх ашгийг хүндэтгэж, хоёр улсын тогтвортой хөгжлийг хангах нь туйлын чухал гэдгийг хүлээн зөвшөөрч, стратегийн харилцан итгэлцлийг гүнзгийрүүлнэ³ хэмээн тунхаглаж, харилцааны баримт бичгийг шинэчлэв. 2010 оны 1 дүгээр сард АНУ Тайваньтай 6,4 тэрбум долларын зэвсэг худалдах гэрээ баталсан тухайгаа мэдэгдэж, мөн оны 2,7 дугаар сард Ерөнхийлөгч Б.Обама Далай ламтай уулзсан зэрэг нь хоёр орны харилцааг ээдрээтэй болгож эхлэв. Харин 2011 оны 1 дүгээр сард Ерөнхийлөгч Б.Обамагийн урилгаар БНХАУ-ын удирдагч Ху Жинтао АНУ-д албан ёсны айлчлал хийх үеэр хоёр улсын харилцааны чиг хандлага, хамтын ажиллагааны цар хүрээг тогтоож, дахин хамтарсан тунхаглал гаргасан

2 Ерөнхийлөгч Б.Обама 2011 оны 11 дүгээр сард Австралийн парламентад хэлсэн үгэндээ “АНУ, Ази, Номхон далайн бүс нутагт, түүний ирээдүйг тодорхойлоход илүү бодитой, удаан үргэлжлэх үүрэг гүйцэтгэнэ” хэмээн онцлон мэдэгдэв. Энэ нь АНУ-ын 2001 оны 9 дүгээр сарын 11-ний хэрэг явдлаас хойш Ойрхи Дорнод руу илүүтэй анхаарч байсан улс төр, батлан хамгаалахын бодлогыг Б.Обамагийн засаг захиргаа Ази, Номхон далайн бүс нутагт шилжүүлнэ гэдгийн илэрхийлэл болов. Цагаан Ордон Ази, Номхон далайд нөлөөгөө бэхжүүлж, нэмэгдүүлэх зорилгоор “дахин тэнцвэржүүлэх бодлого” боловсруулан хэрэгжүүлжээ.

Цолмон. Д., “Барак Обама: АНУ-ын гадаад бодлогын шинэчлэл. Орчин үеийн олон улсын харилцааны чиг хандлага ба Монгол улс”, Орчин үеийн олон улсын харилцааны шинэ чиг хандлага ба Монгол Улс, УБ., 2011. 82-р тал

3 China-US Joint Statement(November 17,2009) <http://www.china-embassy.org/eng/zmgx/doc/more/t944394.htm>(accessed Jan 3, 2017)

байна. Энэхүү тунхаглалдаа хоёр улс нийтлэг ашиг сонирхлоо дэмжих, XXI зууны сорилт, боломжийг шийдвэрлэхийн тулд харилцан ашигтай, бие биенээ хүндэтгэж хамтран ажилласнаар хамтын түншлэлийг бий болгох үүргийг хүлээн⁴ гээд улс орон, ард түмэн хөгжлийн замаа бие даан сонгох эрхтэй, нэг нь нөгөө улсынхаа сонгосон хөгжлийн замыг хүндэтгэх ёстой, хүний эрхийн салбарт оршиж байгаа санал зөрөлдөөнийг хоёр тал эрх тэгш, харилцан хүндэтгэх үзэл санааг баримтлан зохицуулах ёстойг мөн тусгажээ. Үүнээс гадна БНХАУ-ын орлогч дарга Си Зиньпин 2012 оны 2 дугаар сарын 15-нд Вашингтонд тунхагласан гол бодлогынхоо хүрээнд хоёр талын шийдвэрлэх ёстой асуудлуудын эн тэргүүнд харилцан итгэлцлийг бэхжүүлэх шаардлага байгааг онцолж⁵, 2013 онд Элчин сайд Суй Тянькай Америк-Хятадын харилцааг: *хамгийн чухал мөртөө хамгийн мэдрэмтгий, хамгийн ойлгомжтой хэрнээ хамгийн ээдрээтэй, хамгийн ирээдүйтэй боловч хамгийн бэрхшээлтэй*⁶ хэмээн дүгнэсэн зэрэг нь хоёр орны хооронд тулгараад буй асуудал, харилцааны байдлыг оновчтой тодорхойлсон гэж үзэж болно.

Америк-Хятадын нийтлэг ашиг сонирхол нь бүс нутаг болон дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, түүнд сөргөөр нөлөөлж буй зүйлийн эсрэг хамтран үйл ажиллагаа явуулах юм.

Хятад улс 2001 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн үйл явдлын дараа улсын дотоод аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буй СУӨЗО-ны салан тусгаарлах хөдөлгөөн, “Дорнод Туркестан” улсыг сэргээн байгуулах нууц үйл ажиллагааг олон улсын террорист бүлэглэл “Аль Кайда”-тай холбоотой гэж үзэн олон улсын терроризмын эсрэг Америктай идэвхитэйгээр хамтран тэмцэж, хамтын ажиллагаа явуулж эхлэв. Үүнийхээ дагуу хоёр улс дэлхийн энх тайвны төлөө цөмийн терроризмын эсрэг хамтран ажиллах зорилт дэвшүүлжээ. Мөн дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг эрчим хүчний хамтын ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлээд байгаа

4 China-U.S. Joint Statement(January 19,2011)<http://www.china-embassy.org/eng/zmgx/doc/more/t788934.htm> (accessed Jan 3, 2017)

5 **Тайваньд худалдаалах зэвсэгийн худалдаа гэх мэт хоёр орны харилцаанд сөрөг нөлөө үзүүлэх болон Хятад улсын дотоод аюулгүй байдалд хандсан асуудал Kenneth Lieberthal and Wang Jisi, “Addressing U.S.-China Strategic Distrust”, John L.Thornton China Center at Brookings, №4, March 2012, pp.4

6 АНУ-БНХАУ-ын харилцааны тухай Төрийн нарийн бичгийн дарга Жон Керригийн хэлсэн үг, https://mongolian.mongolia.usembassy.gov/helsenug_110414.html

зэрэг олон улсын түвшинд хамтран ажиллаж байгаа нь нэг талаар хоёр орны ашиг сонирхлыг нэгтгэж байна.

Америк-Хятадын ашиг сонирхлын мөргөлдөөн нь Ази, Номхон далайн бүс нутаг дахь бодлогоос тодорхой ажиглагдана.

“Хүйтэн дайн”-ы үед Америк Ази, Номхон далайн бүс нутагт хүчний тэнцвэрийг хадгалахын тулд зарим улс оронтой холбоотон болж байв. Харин өнөө үед Б.Обамагийн засгийн газар 2011 оны сүүл үеэс Ази, Номхон далайн бүс нутагт тэнцвэрийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлээд байгаа юм. Ази, Номхон далайн бүс нутаг дахь үүрэг, оролцоогоо хадгалахаар холбоотон, аюулгүй байдлын түнш орнууд (Япон, Австрали, Вьетнам, Филиппин)-тай харилцаагаа шинэчлэн бэхжүүлж, хамтарсан цэргийн сургуулилт хийж, тус орнуудын аюулгүй байдалд шаардлагатай гэж үзвэл тусламж үзүүлэхээ мэдэгдэв.

2009 оны эдийн засгийн хямралын дараагаас Хятадын жин, нөлөө олон улсын хэмжээнд нэмэгдэх болов. Хятад улс бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлж, өөрийн байр суурийг бэхжүүлэн, нөлөөгөө тэлэх бодлогын хүрээнд хөрш орнуудтай харилцаагаа идэвхжүүлж эхлэв. Хамтын ажиллагааны механизм болох эдийн засгийн “Нэг зам, нэг бүс” төсөл санаачилж, хөрш орнууд руу чиглэсэн дэд бүтцийн хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж, идэвхитэй хамтын ажиллагааг өрнүүлж байгаа.

Эдгээрээс үзэхэд хоёр улсын Ази, Номхон далайн бүс нутаг руу хандсан бодлого нь ашиг сонирхлын зөрчлийг илэрхийлж байгаа юм. Америк-Хятадын улс төрийн харилцаа нь хамтарсан мэдэгдэл, тунхаглал, яриа хэлэлцээний механизмд тулгуурлан улс төр, эдийн засгийн салбарт өрнөж байгаа хэдий ч хоёр орны харилцаа, хамтын ажиллагаанд Өмнөд Хятадын тэнгисийн газар нутгийн маргаан, Америк-Тайваний харилцаа** гэх мэт гадаад болон дотоодын хүчин зүйлс нөлөөлсөөр байна. Америк-Хятадын харилцаа нь нэг үе хүйтэрч, нэг үе хэвийн үргэлжилж ирсэн бөгөөд энэхүү тогтворгүй харилцаа үүсэхэд, харилцан үл итгэх байдал зэрэг нь шууд нөлөөлж байна.

Мөн хоёр орны бүс нутаг руу чиглэсэн бодлогыг харахад нэг талаас холбоотон орнуудаараа дамжуулж өөрийн байр суурийг бэхжүүлэхийг эрмэлзэх Америк, нөгөө талаас өөрийн нөлөөний хүрээг тэлж, шинээр байр сууриа бий болгохыг эрмэлзэх Хятад гэсэн хоёр орны ашиг сонирхол Ази, Номхон далайн бүс нутагт өрнөж байна.

Америк-Хятадын харилцаан дахь Өмнөд Хятадын тэнгисийн газар нутгийн маргааны асуудал

Б.Обамагийн засгийн газар Америк улсын Ойрхи Дорнод (Ирак, Афганистан) руу илүүтэй анхаараад байсан гадаад бодлогыг 2011 оны сүүлээр Ази, Номхон далай руу хандуулж⁷, дахин тэнцвэржүүлэх бодлого тодорхойлов. Энэ бодлогын хүрээнд өөрийн холбоотон, аюулгүй байдлын түнш орнуудын аюулгүй байдлыг хангах тал дээр хатуу байр суурийг баримталж хамтын ажиллагааг эрчимжүүлэхээ мэдэгдсэн юм.

Хятад улсын Өмнөд Хятадын тэнгист хиймэл арал байгуулах, цэргийн бааз, пуужингийн систем байрлуулах⁸, Параселлийн Данкан аралд нисэх буудал барих⁹ зэрэг асуудлаар Америк эсрэг байр суурьтай байгаа. Мөн Хятад улстай газар нутгийн маргаантай байгаа Япон, Филиппин зэрэг Америкийн холбоотон орнуудын аюулгүй байдалд нөлөөлсөн тохиолдолд тусламж үзүүлэхээ мэдэгдэн, Австралийн умард хэсэг (Дарвин хот)-руу 2500 алба хаагчийг илгээж¹⁰, эрэг орчмоор ажиллах чадвартай сөнөөгч онгоцыг Сингапурт байрлуулж¹¹ батлан хамгаалах хамтын ажиллагаагаа идэвхжүүлээд байна.

Өмнөд Хятадын тэнгис дэх газар нутгийн маргаанд өөрийн холбоотон, түнш орнуудын аюулгүй байдлыг хамгаалах, Ази Номхон далайн бүс нутаг, түүний далайн болон агаарын тээврийн аюулгүй байдлыг хангах явдал бол тус бүс нутаг дахь Америкийн оролцоог зайлшгүй бий болгож байна гэж Вашингтон үздэг. Ази, Номхон далайн бүс нутагт явуулж буй Америкийн дахин тэнцвэржүүлэх бодлогыг хятадын судлаачид “Хятадын нөлөөг хязгаарлах бодлого” гэж шүүмжилдэг.

7 Oliver Turner, “Threatening” China and US security: The international politics of identity. Review of International Studies, Vol39, April.2013, pp.3


8 Pentagon report says China weaponizing man-made islands in South China Sea, May 14, 2016 <http://www.foxnews.com/politics/2016/05/14/pentagon-report-says-china-weaponizing-man-made-islands-in-south-china-sea.html> accessed Jan 15, 2017

9 Victor Robert Lee.China Manufactures Land at New Sites in the Paracel Islands, Feb 13.2016, <http://thediplomat.com/2016/02/satellite-images-china-manufactures-land-at-new-sites-in-the-paracel-islands/> accessed Jan15. 2017

10 Joel r.Campbell.US foreign policy towards Northeast Asia Perceptions journal of International Affairs, 2012 VolXVII.№ 4 pp.8

11 Oliver Turner. “Threatening” China and USsecurity: The international politics of identity, Review of International Studies.Vol39, April.2013, pp.20

Зураг №1, Өмнөд Хятадын тэнгис дэх газар нутгийн маргаантай бүс.



Эх сурвалж: Jon Lunn, Arabella Lang, “South China Sea dispute: July 2016 update”, Briefing paper №7481, 12 July, 2016, pp.5

Америк-Хятадын харилцаан дахь Тайвань

Өмнөд Хятадын тэнгист орших Тайваний арал нь далайн эргийн бүсийн стратегийн түшиц газарт, далайн тээврийн гол шугам дагуу оршдог.

Хятадын Тайваний талаарх байр суурь: Анх 1984 онд “Нэг Хятад” бодлого хэмээх үзэл баримтлалыг баталж, түүндээ “нэг улсын дотор социализм, капитализм гэсэн нийгмийн хоёр өөр тогтолцоо оршин байж болно. Эдгээр нь энх тайвнаар урт удаан оршин тогтнож болох ба аль нь ч алианаа устгаж үл чадна”¹² гэж заажээ. Үүний дараа 1995 онд Зян Зэминь “Найман зүйл зорилт”, 2005 онд Ху Жинтао “Дөрвөн зүйл санал” дэвшүүлж хоёр эргийн харилцааг зохицуулах, хөгжүүлэх үзэл баримтлал бий болгосон байна.

Америкийн Тайваний талаарх байр суурь: 1972 онд анх Америк, Хятадын хамтарсан мэдэгдэл хийж Тайваний хоолойн хоёр эрэг нь нэг улс мөн.

12 Пагмажав. З., “Тайваний талаархи Хятадын бодлого буюу хоёр эргийн эдийн засаг, худалдааны харилцааны “дулаарал””, Стратеги судлал сэтгүүл, УБ., 2009, № 46, 33-р тал

БНХАУ нь цорын ганц хууль ёсны засгийн газар мөн гэсэн Хятадын байр суурийг Америк хүлээн зөвшөөрчээ.¹³ Америк улс 1979 онд Хятад улстай дипломат харилцаа тогтоосноос дөрвөн сарын дараа “Тайваньтай Харилцах Акт (The Taiwan Relations Act)”-ыг баталсан¹⁴ бөгөөд мөн дипломат харилцаа тогтоох тухай хамтарсан мэдэгдэлдээ Америк-Тайваний албан бус харилцаа болон соёлын хамтын ажиллагааг тус тус тусгаж өгчээ. Энэ нь Тайваньтай харилцах, аюулгүй байдлыг хамгаалах, зэвсэг худалдаалах тулгуур баримт бичиг болдог.

Хоёр орны хувьд Тайваний талаар баримтлах хамтарсан мэдэгдэл байдаг боловч “Тайваньтай Харилцах Акт”-ыг Америк улс давхар харгалзан үздэг байна. Хятад улс, Тайваний зэвсэг худалдан авах зэрэг Америк улстай бие даан харилцаж буй явдлыг эрс эсэргүүцдэг. 2010 оны 1 дүгээр сарын 29-нд 6,392 тэрбум доллар¹⁵, 2011 оны 9 дүгээр сарын 21-нд 5,85 тэр бум доллар¹⁶, 2015 оны 12 дугаар сарын 12-нд 1,83 тэрбум доллар¹⁷-ын зэвсгийг тус тус Тайваньд худалдах тухайгаа Б.Обамагийн Засгийн газар зарласан. Үүнийг Хятад улс олон улсын хууль, олон улсын харилцааны үндсэн хэм хэмжээ болон Хятадын бие даасан аюулгүй байдалд хөндлөнгөөс оролцож байна хэмээн эсэргүүцэж, үндэсний ашиг сонирхлоо хангах үүднээс зэвсгийн худалдаанд оролцож буй байгууллагуудад зохих хориг арга хэмжээ авахаа Гадаад хэргийн дэд сайд Зэн Зэгуан тухайн үед мэдэгдэж байжээ.¹⁸

Америк-Хятадын харилцааны түүхийг өрсөлдөөн хийгээд хамтын ажиллагаа өрнөсөн, харилцан үл итгэлцсэн байр сууринаас хандаж ирсэн хэмээн судлаачид дүгнэжээ. Тухайлбал, Австралийн Гриффит Их сургуулийн дэд профессор Кай Хэ “Америк-Хятадын харилцааг тайлбарлах нь: Неоклассик реализмын болон аюул занал,

13 Joint communique between the People’s Republic of China and the United States of America, Shanghai, Feb 28, 1972, <https://history.state.gov/historicaldocuments/frus1969-76v17/d203>(accessed Jan 6, 2017)

14 Shirley A. Kan, Wayne M. Morrison, U.S.-Taiwan Relationship: Overview of Policy Issues, Congressional Research Service Report Dec 11, 2014, <https://fas.org/sgp/crs/row/R41952.pdf>.

15 Special Commentary: US-Taiwan Business Council Welcomes Congressional Notification of Sales to Taiwan of PAC-3 Missile Units, BLACK HAWK Helicopters, OSPREY Ships, HARPOON Missiles and MIDS/LVT-1 Terminals. <http://www.ustaiwandefense.com/tags/notifications/>(accessed Jan 8, 2017)

16 Background Briefing: Notification to Congress on the Sale of Arms to Taiwan <https://www.state.gov/r/pa/prs/ps/2011/09/172936.htm>(accessed Jan 8, 2017)

17 Obama administration authorizes \$1.83 billion arms sale to Taiwan. <http://www.reuters.com/article/us-usa-taiwan-arms-idUSKBN0TZ2C520151216>(accessed Jan 9, 2017)

18 Ibid.

ашиг сонирхлын харилцааны тухай”¹⁹ хэмээх өгүүлэлдээ, хоёр улсын дипломат харилцаа тогтоосноос хойших эдийн засаг, цэрэг армийн харилцааг дөрөв үечилжээ. Үүнд:

- » 1949-1969 онд цэрэг армийн өрсөлдөөн (military competition) өрнөсөн харилцаа
- » 1970-1989 онд цэрэг армийн хамтын ажиллагаа (military cooperation) өрнөсөн харилцаа
- » 1989-2009 онд эдийн засгийн хамтын ажиллагаа (economic cooperation) өрнөсөн харилцаа
- » 2010 оноос хойш эдийн засгийн өрсөлдөөн (economic competition) өрнөсөн харилцаа хэмээн үзсэн байна.

Харин Принстон Их сургуулийн профессор Аарон Фридберг “Америк-Хятадын ирээдүй: Мөргөлдөөн үүсэх үү?”²⁰ гэсэн судалгаандаа өнөөгийн нөхцөл байдлыг хамтын ажиллагаа, өрсөлдөөн хосолсон шинжтэй гэж тодорхойлсон бол Броокин Институтаас гаргасан Ван Жиши, К.Либертал нарын “Америк-Хятадын үл итгэх стратеги”²¹ судалгаанд хэд хэдэн тодорхой хүчин зүйлээс шалтгаалан (улс төрийн өөр өөр тогтолцоо, хүний эрхийн зөрчил, хурдтай өсөн нэмэгдэж байгаа эдийн засаг г.м) харилцан бие биедээ үл итгэсэн байр сууринаас хандсан хамтын ажиллагаа өрнөдөг хэмээн тэмдэглэжээ.

Дээрх судлаачдын судалгаа, дүгнэлтээс үзвэл Америк-Хятадын харилцаа өнөөг хүртэл хамтын ажиллагаа болон өрсөлдөөний шинжтэй өрнөж иржээ. Хоёр өөр тогтолцоо нь харилцан үл итгэсэн байр суурийг бий болгож, өөр өөрийн улсын нэр хүнд, нөлөөг олон улсад хадгалах, өсгөн нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого явуулж иржээ хэмээн дүгнэж болох юм. 2005 оноос хойш Америк улс “Хятадын аюул” байна гэж үзсээр ирсэн байдаг.

Д.Трампын шинэ засаглал ба Америк-Хятадын харилцаа

Америкийн гадаад бодлогын хэтийн төлөвийг судлаачид Д.Трампын мөрийн хөтөлбөр, уриалгад тулгуурлан таамаглал дэвшүүлж байна. АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдсон Д.Трамп гадаад бодлогоо хэрэгжүүлэхдээ Америкийн аюулгүй байдал, эрх ашгийг тэргүүнд тавьж, *America First* буюу *Америк тэргүүнд, Make*

19 Kai He, Explaining U.S-China relations: neoclassical realism and the nexus of threat-interest perceptions, *The Pacific Review*, Vol.16, 2003

20 Aaron L.Friedberg, The Future of U.S-China Relations: Is Conflict Inevitable?, *International Security*, Vol.30, No.2, 2005

21 K. Liberal, Wang Jisi, Addressing U.S.-China Strategic Distrust, *Brooking institution*, 2012

America great again буюу Дахин хүчирхэг Америкийг бүтээнэ гэсэн уриалгыг баримталж гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа явуулна хэмээн онцолж байна.

Түүнчлэн кампанит ажлынхаа туршид гадаад харилцаандаа хязгаар тавьж, Америк улс дэлхийн бүхий л асуудалд оролцох явдлыг багасган, холбоотон орнуудын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг бүрэн хангадаг байдлаас татгалзаж, *Isolationism* буюу тусгаарлах бодлогыг гадаад болон аюулгүй байдлын гол зарчмаа болгож²², эдийн засгийн хувьд *protectionism* буюу хамгаалах бодлого баримтлах²³-аа мэдэгдсэнээр холбоотон орнууд тодорхой хэмжээнд сандарч эхлээд байгаа юм.

Эдийн засгийн хамгаалах бодлогын хүрээнд ашиггүй эдийн засгийн хамтын ажиллагаанаас эрс татгалзан, Номхон далай дамнасан түншлэл (TPP-Trans Pacific Partnership)²⁴-ээс гарч, мөн Америкийн эдийн засгийг алдагдалд оруулж буй импортын хямд бараа бүтээгдэхүүнд хяналт тавьж, бусад улс оронтой хийж байгаа худалдааны тэнцвэргүй байдлыг арилган үндэсний эрх ашгийг тэргүүнд тавина гэдгээ мэдэгдэв.

Америк-Хятадын улс төрийн харилцаанд нөлөөлдөг гол хүчин зүйл нь худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагаа юм. 2015 онд Америкийн нийт экспорт 1.51 их наяд ам.доллар байснаас 7,7%-ийг Хятад руу гаргасан экспорт эзэлж байна. Харин нийт импорт 2.273 их наяд ам.доллар байснаас 21,5% нь Хятадад оногдож байна.²⁵

2015 оны байдлаар хоёр улс 599 тэрбум ам.долларын худалдаа хийснээс алдагдал нь 367 тэрбум ам.доллар²⁶ байсан бол 2016 оны байдлаар худалдааны хэмжээ 577 тэрбум доллар байснаас Америкийн худалдааны алдагдал нь 347 тэрбум доллар²⁷-т хүрчээ. 2016 оны 11 дүгээр сарын байдлаар Америкийн худалдааны нийт алдагдал 45,2 тэрбум ам.доллар²⁸-т хүрсэн байна. Америк Хятадтай хийсэн

22 Kim Hyun-wook. Foreign Policy of the New U.S.Administration and Forecast on the Korean Peninsula Policy.IFANS Focus. Nov.12.2016

23 Ibid

24 Stephen Dinan. Donald Trump to withdraw U.S. from Asian trade pact on his first day in office.<http://www.washingtontimes.com/news/2016/nov/21/donald-trump-withdraw-us-trans-pacific-partnership/>

25 <https://www.cia.gov/library/publications/resources/the-world-factbook/geos/us.html>

26 U.S.-China Trade Facts, <https://ustr.gov/countries-regions/china-mongolia-taiwan/peoples-republic-china>

27 Trade in Goods with China, <https://www.census.gov/foreign-trade/balance/c5700.html>

28 U.S. international trade in goods and services November 2016. U.S. Census Bureau of Economic Analysis accesses Jan 06. 2017 http://census.gov/foreign-trade/Press-Release/current_press_release/ft900.pdf

худалдаандаа сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд байнга алдагдал хүлээгээд байгаа юм.

Д.Трампынхаар Америкийн гадаад худалдааны алдагдлын гол шалтгаан нь Хятадаас импортолж буй хямд бараа бүтээгдэхүүн гэж үзээд, Хятадаас орж ирэх бараа бүтээгдэхүүнд 45% хүртэлх гаалийн татвар ноогдуулах²⁹ санаачилгыг гаргаад байгаа юм. Мөн Зүүн Азийн бүс нутгийн геополитикийн асуудлыг шийдвэрлэхэд Хятадын оролцоог нэмэгдүүлж, Умард Солонгосын цөмийн зэвсэглэлийн асуудалд хяналт тавьж чадахгүй байгаа тохиолдолд Хятадтай худалдааны харилцааг үргэлжлүүлэхэд хүндрэлтэй байх болно³⁰ гэж мэдэгдэв. Сонгуульд ялалт байгуулсаныхаа дараа 12 дугаар сарын 2-ны өдөр Тайваний ерөнхийлөгч Цай Ин-вэнтэй утсаар ярьж, Өмнөд Хятадын тэнгис дэх Хятадын цэргийн стратеги тэлж байгааг анхааруулсан³¹ зэрэг нь Бээжингийн эгдүүцлийг хүргээд байгаа. Хятадын судлаачид Д.Трампын үйлдлийг 37 жилийн турш хэвийн үргэлжилж ирсэн дипломат харилцаанд сэв суулгаж байна хэмээн үзэж байна.

Д.Трамп Хятадыг валют болон худалдааны бодлогоо эргэн харгахгүй бол “Нэг Хятад” бодлогыг дахин хэлэлцэнэ³² хэмээн мэдэгдсэний дараа 2016 оны 1 дүгээр сарын 15-нд Хятадын ГХЯ-ны хэвлэлийн төлөөлөгч Лу Кан “Нэг Хятад” бодлого нь Америк-Хятадын улс төрийн харилцааны суурь болохоос, тохиролцооны хэрэгсэл биш бөгөөд БНХАУ-ын засгийн газар Хятадыг төлөөлөх цорын ганц хууль ёсны засгийн газар мөн³³ гэсэн мэдэгдлийг хийж хоёр тал үгээр сөргөлдөж байгаа нь хоёр орны цаашдын улс төр, эдийн засгийн харилцаанд бэрхшээл үүсгэх магадлалтай. Харин Д.Трампын засаг захиргаа бүрэн сонгогдсоны дараа л худалдааны томоохон түнш Хятадтай хэрхэн харилцах нь тодорхой болох юм.

Мөн Б.Обамагийн хэрэгжүүлж байсан “Ази, Номхон далайн дахин тэнцвэржүүлэх бодлого”-той Д.Трамп санал нийлэхгүй байна³⁴ гэдгээ илэрхийлж, бүс нутаг дахь АНУ-ын цэргийн тоо хэмжээг

29 Mira Rapp-Hooper. Deciphering Trump's Asia Policy. <https://www.foreignaffairs.com/articles/asia/2016-11-22/deciphering-trumps-asia-policy> accessed November 22, 2016

30 Trump on the Issue. Council on Foreign Relations. <http://www.cfr.org/campaign/2016/>

31 Tao Wenzhao. China-US relation in 2016. <http://www.chinausfocus.com/foreign-policy/china-us-relations-in-2016>

32 Beijing rejects Trump's suggestion to negotiate one-China policy, <http://www.chinapost.com.tw/taiwan/national/national-news/2017/01/15/489469/Beijing-rejects.htm>

33 China hits back at Trump, says one-China policy is 'non-negotiable', <http://www.foxnews.com/politics/2017/01/15/china-hits-back-at-trump-says-one-china-policy-is-non-negotiable.html>

34 Simon Shen, A Preview of Trump's Foreign policy Towards China, <http://foreignpolicyblogs.com/2016/12/07/preview-trump-foreign-strategy-china/> accessed Dec 06, 2016

багасгах тухайгаа хэд хэдэн удаа мэдэгдсэн гэсэн хэдий ч гадаадад тэнцвэржүүлэх стратеги (offshore balancing strategy)-ийг үргэлжлүүлж, Ази руу чиглэсэн “Манлайлал”-ыг олон улсын эрхзүйд тулгуурлан бий болгох³⁵ ёстой хэмээн тодорхойлсон байна.

ДҮГНЭЛТ

Дэлхийн II дайны дараагаас хүчирхэгжиж эхэлсэн Америк болон сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж байгаа Хятад улсын хоорондох улс төрийн харилцаа нь хамтын ажиллагааны яриа хэлэлцээр, хамтарсан мэдэгдэл, тунхаглалын түвшнээс цааш хөгжөөгүй хэдий ч эдийн засгийн харилцаа ихээхэн гүнзгийрсэн байна.

Хятад улс, Америктай хэвийн харилцаагаа хадгалж үлдэхийг эрмэлзэх нь тодорхой боловч Д.Трампын “эдийн засгийн хамгаалах бодлого” болон БНХАУ-аас нийлүүлж буй бараа бүтээгдэхүүнд өндөр татвар тогтоох, Солонгосын хойгийн асуудалд шахалт үзүүлэх, Номхон далай дамнасан түншлэлээс гарах зэргээс харахад, хэрэв АНУ-д эдийн засгийн алдагдалгүй, ашигтай харилцаа бий болох тохиолдолд хоёр орны харилцаа хэвийн үргэлжлэх төлөвтэй байна. Гэвч АНУ-ын шинэ ерөнхийлөгч Д.Трамп “Америк тэргүүнд” стратегийг хэрэгжүүлэхдээ эдийн засгийн хувьд Хятадтай илүү хатуу байр сууринаас хандах магадлалтай.

Д.Трамп сонгуулийн мөрийн хөтөлбөрөө танилцуулах үеэрээ Б.Обамагийн засаг захиргааны хэрэгжүүлж байгаа Ази, Номхон далайн тэнцвэржүүлэх бодлогыг сайшаахгүй байгаагаа мэдэгдэж, бүс нутаг дахь цэргийн хүчийг багасгах тухай дурдаж байснаас үзвэл тус бүс нутаг дахь Америкийн “тэнцвэржүүлэх бодлого”-ын хүч сулрах магадлалтай юм. Мөн түүнчлэн Тайваний ерөнхийлөгчтэй утсаар ярьсан болон “Нэг Хятад” бодлогыг дахин хэлэлцэж үзнэ хэмээсэн зэрэг нь Америк-Хятадын харилцаанд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай ч Д.Трамп ажлаа хүлээж аван, Пентагоны томилгоо бүрэн хийгдсэний дараа хоёр орны цаашдын харилцааны таамаглалыг гаргахад илүү дөхөмтэй болох юм.

35 Kim Hyun-wook. Foreign Policy of the New U.S. Administration and Forecast on the Korean Peninsula Policy. IFANS Focus. Nov. 12. 2016

Өмнөд хөрш БНХАУ, гуравдагч түнш гэгдэх АНУ-ын харилцаа нь манай улсын хувьд ч мөн судлаачдын анхаарлыг татсаар байна.

Ном зүй

1. Пагмажав.З., “Тайваний талаархи Хятадын бодлого буюу хоёр эргийн эдийн засаг, худалдааны харилцааны “дулаарал””, Стратеги судлал сэтгүүл, УБ., 2009, № 46,
2. Цолмон.Д., “Барак Обама: АНУ-ын гадаад бодлогын шинэчлэл. Орчин үеийн олон улсын харилцааны чиг хандлага ба Монгол улс”, Орчин үеийн олон улсын харилцааны шинэ чиг хандлага ба МонголУлс, УБ., 2011.
3. Aaron L.Friedberg, The Future of U.S-China Relations: Is Conflict Inevitable?, International Security, Vol.30, No.2, 2005.
4. Kai He, Explaining U.S-China relations: neoclassical realism and the nexus of threat-interest perceptions, The Pacific Review, Vol.16, 2003
5. Kenneth Lieberthal and Wang Jisi, “Addressing U.S.-China Strategic Distrust”, John L.Thornton China Center at Brookings, №4, March 2012.
6. Kim Hyun-wook, Foreign Policy of the New U.S.Administration and Forecast on the Korean Peninsula Policy, IFANS Focus, Nov,12.2016.
7. Oliver Turner, “Threatening” China and US security: The international politics of identity. Review of International Studies, Vol39, April.2013.
8. Joel r.Campbell, US foreign policy towards Northeast Asia Perceptions journal of International Affairs, Vol XVII. № 4,2012.

Цахим эх сурвалж:

1. China-US Joint Statement (November 17, 2009) <http://www.china-embassy.org/eng/zmgx/doc/more/t944394.htm>-АНУ дахь БНХАУ-ын Элчин Сайдын Яамны амлбан ёсны сайт

2. China-U.S. Joint Statement (January 19, 2011) <http://www.china-embassy.org/eng/zmgx/doc/more/t788934.htm>- АНУ дахь БНХАУ-ын Элчин Сайдын Яамны албан ёсны сайт
3. АНУ-БНХАУ-ын харилцааны тухай Төрийн нарийн бичгийн дарга Жон Керригийн хэлсэн үг, https://mongolian.mongolia.usembassy.gov/helsenug_110414.html- Монгол дахь БНХАУ-ын Элчин Сайдын Яамны амлбан ёсны сайт
4. Joint communique between the People's Republic of China and the United States of America, Shanghai, Feb 28, 1972, <https://history.state.gov/historicaldocuments/frus1969-76v17/d203>- АНУ-Олон нийтийн харилцааны товчооны албан ёсны сайт
5. Background Briefing: Notification to Congress on the Sale of Arms to Taiwan <https://www.state.gov/r/pa/prs/ps/2011/09/172936.htm>-АНУ-ын Төрийн департаментийн албан ёсны сайт
6. U.S.-China Trade Facts, <https://ustr.gov/countries-regions/china-mongolia-taiwan/peoples-republic-china>-АНУ-ын Худалдааны төлөөлөгчийн газрын албан ёсны сайт
7. Trade in Goods with China, <https://www.census.gov/foreign-trade/balance/c5700.html>-АНУ-ын Хүн амын тооллогын товчооны албан ёсны сайт
8. U.S. international trade in goods and services November 2016. U.S. Census Bureau of Economic Analysis accesses Jan 06, 2017 http://census.gov/foreign-trade/Press-Release/current_press_release/ft900.pdf-АНУ-ын Хүн амын тооллогын товчооны албан ёсны сайт <https://www.cia.gov/library/publications/resources/the-world-factbook/geos/us.html>- АНУ-ын Тагнуулын төв газрын албан ёсны сайт
9. Obama administration authorizes \$1.83 billion arms sale to Taiwan. <http://www.reuters.com/article/us-usa-taiwan-arms-idUSKBN0TZ2C520151216>-Рейтерс агентлагын албан ёсны сайт
10. China hits back at Trump, says one-China policy is 'non-negotiable', <http://www.foxnews.com/politics/2017/01/15/china-hits-back-at-trump-says-one-china-policy-is-non-negotiable.html>- foxnews-ийн албан ёсны сайт
11. Pentagon report says China weaponizing man-made islands in South China Sea, May 14, 2016 <http://www.foxnews.com/politics/2016/05/14/pentagon-report-says-china-weaponizing-man-made-islands-in-south>

- [china-sea.html](#)
12. Victor Robert Lee. China Manufactures Land at New Sites in the Paracel Islands, Feb 13,2016, <http://thediplomat.com/2016/02/satellite-images-china-manufactures-land-at-new-sites-in-the-paracel-islands/-the-diplomat.com-ийн албан ёсны сайт>
 13. Mira Rapp-Hooper. Deciphering Trump's Asia Policy. <https://www.foreignaffairs.com/articles/asia/2016-11-22/deciphering-trumps-asia-policy>—Гадаад харилцааны зөвлөл
 14. Trump on the Issue. Council on Foreign Relation. <http://www.cfr.org/campaign2016/>-
 15. Tao Wenzhao. China-US relation in 2016. <http://www.chinausfocus.com/foreign-policy/china-us-relations-in-2016> -АНУ-БНХАУ-ын судалгааны институцийн албан ёсны сайт
 16. Stephen Dinan, Donald Trump to withdraw U.S. from Asian trade pact on his first day in office. <http://www.washingtontimes.com/news/2016/nov/21/donald-trump-withdraw-us-trans-pacific-partnership/>-Вашингтон таймсийн албан ёсны сайт
 17. Special Commentary: US-Taiwan Business Council Welcomes Congressional Notification of Sales to Taiwan of PAC-3 Missile Units, BLACK HAWK Helicopters, OSPREY Ships, HARPOON Missiles and MIDS/LVT-1 Terminals. <http://www.ustaiwandefense.com/tags/notifications/>-Тайваний батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлын албан ёсны сайт
 18. Shirley A. Kan, Wayne M. Morrison, U.S.-Taiwan Relationship: Overview of Policy Issues, Congressional Research Service Report Dec 11,2014, <https://fas.org/sgp/crs/row/R41952.pdf>.
 19. Beijing rejects Trump's suggestion to negotiate one-China policy, <http://www.chinapost.com.tw/taiwan/national/national-news/2017/01/15/489469/Beijing-rejects.htm> - Тайваний үндэсний мэдээний албан ёсны сайт
 20. Simon Shen, A Preview of Trump's Foreign policy Towards China, <http://foreignpolicyblogs.com/2016/12/07/preview-trump-foreign-strategy-china/> -Нью Йорк хот дахь нээлттэй форумын албан ёсны сайт